2026 оны Гадаад иргэдийн хүний эрхийн лидер сонгон шалгаруулах мэдээлэл

□ **(Бүртгэлийн хугацаа)** 2026 оны 6-р сарын 16 (Мягмар) 09:00~ 2026 оны 6-р сарын 30 (Мягмар)18:00 хүртэл

□ **(Сонгон шалгаруулах хүний тоо)** 50 хүн, Хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн яамны хэлтэс(төлөөлөгч салбар нэгж) тус бүрээс 10 хүртэл хүн

* Гадаад иргэдтэй холбоотой байгууллагаас (Гадаад ажиллах хүчний зөвлөгөө өгөх төв, Гадаад ажилчдыг дэмжих төв, Гадаад иргэдийн төв гэх мэт) санал болгосон тохиолдолд давуу эрхтэйгээр сонгон шалгаруулна.

□ **(Хүсэлт гаргагчид тавигдах шаардлага)** БНСУ-д хууль ёсны оршин суух эрхтэй гадаадын иргэдээс дотоодын аж ахуйн нэгжид ажилласан туршлага нь 2-оос дээш жил, эх хэлээрээ болон солонгос хэлээр харилцах чадвартай байх.

* Зар нийтлэгдсэн өдрийн байдлаар эрх зүйн зөрчилгүй, мөн оршин суух визийн ангиллаас шалтгаалан “Гадаад иргэдийн хүний эрхийн лидер” үйл ажиллагаанд оролцоход саадгүй хүнийг сонгон шалгаруулна.

○ **(Давуу эрхийн нөхцөл)** Доорх шаардлагад хамаарах хүмүүсийг давуу эрхтэйгээр сонгон шалгаруулна.

- Хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн яам (Үйлдвэрлэлийн хүний нөөцийн корпораци, Гадаад ажиллах хүчний зөвлөгөө өгөх төв, Гадаад ажилчдыг дэмжих төв), орон нутгийн байгууллага (Гадаад ажиллах хүчний дэмжлэгийн төв, Гадаад иргэдийн төв), сайн дурын байгууллага зэрэг гадаад иргэдтэй холбоотой байгууллагаас тодорхойлж санал болгосон хүн

* Дээрх нөхцөлд хамаарах хүн нь тодорхойлолт хавсаргах шаардлагатай.

- Гадаадын иргэдэд чиглэсэн үйл ажиллагаа явуулдаг байгууллага, эсвэл гадаадын иргэдийг дэмжих байгууллагад ажиллаж байсан туршлагатай байх

- Өөрийн орны иргэд · бүс нутгийн хамтын нийгэмлэг, гадаад иргэдийг дэмжих байгууллага зэрэгт ажиллаж байсан туршлагатай

- TOPIK 4-р түвшин* ба түүнээс дээш оноотой, эсвэл Нийгмийн нэгдсэн хөтөлбөрийн 4-р шат ба түүнээс дээш түвшин дүүргэсэн хүн, эсвэл түүнтэй дүйцэхүйц чадвартай хүн

* Солонгос хэлний чадвар(TOPIK) 4-р түвшин: Өдөр тутмын ажил үүрэг гүйцэтгэхэд шаардлагатай унших, сонсох, бичих, ярих чадвартай бөгөөд

мэдээ, сонины энгийн агуулгыг ойлгох түвшин

□ **(Үйл ажиллагааны чиглэл)** Гадаад иргэдийн эрх ашиг зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, хүний эрхийг хамгаалах үйл ажиллагаа

○ **(Эрх зөрчигдсөн тохиолдол илрүүлэх)** Орон нутаг дахь гадаад иргэдэд тулгарч буй шударга бус харилцаа, ялгаварлан гадуурхалт зэрэг эрх зөрчигдсөн тохиолдлыг илрүүлж, орон нутгийн Хөдөлмөр эрхлэлтийн албанд мэдээлэх·мэдэгдэх

* Хүний эрхийн лидер нь <тохиолдлын бүртгэл> [түр нэр] гаргаж өгнө. (Хүчирхийлэл зэрэг ноцтой хүний эрхийн зөрчил гарсан тохиолдолд орон нутгийн хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн газрын холбогдох байгууллагад даруй мэдээлнэ.)

○ **(Уулзалтанд оролцох)** Ээлжит уулзалтад (улирал тутамд явагдах ба шаардлагатай үед нэмэлтээр) оролцож, гадаад иргэдийн эрх зөрчигдсөн тохиолдол болон санал бодлыг дамжуулж мэдээлэх

○ **(Хүний эрхийн ментор)** Гадаад ажилчидад эрхээ хамгаалах журам, холбогдох байгууллагын талаар мэдээлэл өгөх, орчуулга болон хэлмэрчлэх үйлчилгээ үзүүлэх зэрэг гадаад иргэдийн хүний эрхийн үйл ажиллагааны гүүр болох

○ **(Сурталчилгаа· мэдээлэл)** Гадаад ажилчдын хөдөлмөрийн эрхийг хамгаалахтай холбоотой гол бодлого, мэдээллийн материал болон кампанит ажлыг сошиал сувгаар сурталчлах, түгээх

○ **(Орчуулах·орчуулга хянах)** Гадаад иргэдийн хүний эрхийг хамгаалахтай холбоотой сургалтын материал, танилцуулга зэргийг орчуулах болон орчуулгыг хянах гэх мэт

□ **(Үйл ажиллагаа явуулах хугацаа)** Сонгогдсон өдрөөс эхлэн 1 жил (2027 оны 6-р сарын сүүлд дуусгах төлөвлөгөөтэй)

□ **(Бүрдүүлэх материал)** ① Өргөдлийн маягт (Хувийн мэдээлэл цуглуулах· ашиглах· дамжуулах зөвшөөрлийн хамт), ② Тодорхойлолт / санал болгосон тодорхойлолт, ③ Шаардлага хангасаныг нотлох баримт бичиг, ④ Холбогдох нотлох баримт

* Орон нутгийн Хөдөлмөр эрхлэлтийн алба (Гадаад ажиллах хүчний хэлтэс)нд өөрийн биеэр хүргэх, шуудангаар эсвэл имэйлээр илгээх

□ **(Үйл ажиллагааны урамшуулал)** Гадаад иргэдийн хүний эрхийн лидерээр сонгогдсон батламж гардуулах, уулзалт хуралд оролцсон урамшуулал болон бусад үйл ажиллагааны зардал олгох, шилдэг оролцогчдыг урамшуулах зэрэг урамшуулал олгоно.

□ **(Сонгон шалгаруулах дараалал)** Материалыг хүлээж аван шалгаруулах болон ярилцлага (2026 оны 7-р сарын эхээр)→ Тэнцсэн хүмүүсийг зарлах (2026 оны 7-р сард)

* Материалаар шалгаруулсны дараа ярилцлагын товыг тусад нь мэдэгдэх ба эцсийн шатанд тэнцсэн хүмүүстэй хувьчилж холбогдон мэдэгдэнэ.

□ **(Лавлах утас)** Хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн яам (☎1350) эсвэл Хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн яамны Гадаад ажиллах хүчний төв (сонгон шалгаруулах зарлалаас дэлгэрэнгүй мэдээлэл авна уу.)